

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, “Ай Эн Ди” ХХК НАРЫН ХООРОНД
БАЙГУУЛСАН “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ
ТУХАЙ ГЭРЭЭ”-НИЙ 2023 ОНЫ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2024 оны 2 дугаар сарын 2

Баянхонгор хот

д/д	№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлт	Гүйцэтгэл / тайлан/	Үнэлгээ /хувь/
1	2	3	4	5
1	3.1.1	Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;	Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллахад орон нутгийн иргэд, төрийн байгууллага болон бусад хуулийн этгээдээс саад учруулсан аливаа асуудал саад бэрхшээл гараагүй болно.	100%
2	3.1.2	Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;	Ажлын байрны зарыг орон нутгийн иргэдийн цахим сүлжээнд нээлттэй байршуулж тэргүүн ээлжинд орон нутгийн иргэдийг ажилд авах бодлого баримтлан ажилласан. Орон нутгаас орсон ажилчиддаа ажил эхлэхийн өмнө ХААБ болон ажлын байрны онцлогт шаардлагатай дадлагашуулах сургалтанд хамруулж ажлын талбарт гаргадаг. 2023 оны 6-р сард Уул уурхайн аврах ангид хүсэлт гаргаж уурхайн нийт ажилчдад гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ, бэлэн байдлын тухай сургалт хийлгэсэн.	70%
3	3.1.3	Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;	Бүх ажилчдыг ХААБ-ын үндсэн болон ажлын байрны онцлогт тохирсон тусгай сургалтуудад хамруулдаг. Кемпийн гал тогоо, тээврийн хэрэгсэл, механизмуудын техник үйлчилгээ, насосчин, дизельчин, хүнд механизмын оператор, жолооч зэрэг ажлын байруудад орон нутгийн ажилчид ажилладаг бөгөөд, тэдгээр ажилчдыг машин механизм дээр дадлагажуулах, дагалдан сургах зэрэг ажлуудыг зохион байгуулдаг.	100%

1	2	3	4	5
4	3.1.4	Ажиллах хүчнийхээ 50-иас доошгүй хувийг орон нутгаас ажиллуулах, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажилд авах;	Уурхай дээрх нийт ажиллагсдын 80 хувийг орон нутгийн ажилчдаас бүрдүүлсэн. Орон нутгийн ажилчдыг ажилд авахдаа хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээллийн санд бүртгэлтэй эсэхийг тодруулаагүй. 2023 онд тус уурхайд ажилласан нийт 31 ажилтнаас механизмын оператор, жолооч, баяжуулагч, дизельчин, туслах, тогооч, үйлчлэгч зэрэг ажлын байруудад Баянхонгор аймгийн харъяат нийт 22 иргэн ажилладаг. Ажилчдын судалгааг хавсаргав.	100%
5	3.1.5	Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх	Уурхайн бүс нутагт амьдардаг иргэдтэй өдөр тутам холбоотой байдаг бөгөөд уурхайн үйл ажиллагааны явцын талаар иргэдэд чөлөөтэй мэдээлж, санал хүсэлтийг байнга хүлээж авдаг. Бөмбөгөр сумын 2-р багийн иргэдийн хуралд оролцож уурхайн 2023 оны үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн.	100%
6	3.1.6	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг биелүүлж ажиллах;	2023 оны Байгаль Орчны Менежментийн Тайланг БОАЖЯ-аар хянуулж байгаа.	100%
7	3.1.7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх;	2023 онд 6,4 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнийх үрээнд 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөснөөс 7,29 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалахаар 5,5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг MNS:5917:2008 стандартын дагуу хийн аймгийн байгаль орчны комисст хүлээлгэж өгсөн. Нөхөн сэргээлтийн актыг хавсаргав.	100%

1	2	3	4	5
8	3.1.8	Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;	Тухайн жилд орон нутагт байгалийн гамшиг, түүнтэй адилтгах хүн хүч, техник тоног төхөөрөмжийн туслалцаа шаардлагатай үйл явдал тохиолдоогүй.	100%
9	3.1.9	Гурван талууд бүгд зөвшөөрсөн тохиолдолд зохион байгуулалтад орсон бичил уурхайн нөхөрлөлүүдтэй гурвалсан гэрээний үндсэн дээр талбай олгох, хамтран ажиллах; /Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батласан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дэх заалт/	Бичил уурхайн нөхөрлөлүүдээс хамтран ажиллах хүсэлт ирээгүй тул ямар нэгэн хамтран ажиллах гурвалсан гэрээ хийгдээгүй. .	100%
10	3.1.10	Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах.	2023 онд хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтуудын үеэр тус уурхайн талбайд ямар нэгэн зөрчил илрээгүй учир эрх бүхий албан тушаалтнуудаас албан шаардлага, акт тавигдаагүй.	70%
11	3.1.11	Уул уухайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх,	Ашигт Малтмалын Хайгуул, Олборлолт, Үйлдвэрлэл Эрхэлдэг Аж Ахуйн Нэгж, Байгууллагын Үйл Ажиллагааны 2023 оны Тайланг хийж Олборлох Үйлдвэрлэлийн Ил тод Байдлын Ажлын Албанд 2024 оны 3-р сарын 1-ний дотор тайлагнана.	100%
12	3.1.12	Олборлосон металлыг Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Монгол банк болон эрх бүхий арилжааны банкинд тушааж байх;	2023 онд нийт 11.23 кг үнэт металл олборлон Баруун бүсийн үнэт металлын сорьц тогтоох лабораториор баталгаажуулж, Баянхонгор аймгийн Голомт банкинд тушаасан.	100%

1	2	3	4	5
13	3.1.13	Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг бүрэн хангасан тохиолдолд ажлаа эхэлж байх.	Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг хангасан.	100%
14	3.1.14	Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг сум орон нутгийн өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах	Гэрээний 9.2-т заасан хуваарийн дагуу 2023 оны 6-р сарын 19-ний өдөр "Хонгорын төлөө бидний сэтгэл" ТББ-д 10 сая төгрөгийг, 2023 оны 7-р сарын 1-ны өдөр "Энх Утир" ХХК-д 30 сая төгрөгийг, 2023 оны 9-р сарын 1-ны өдөр "Есөн Од Констракшн" ХХК-д 10 сая төгрөгийг, 2023 оны 10-р сарын 26-ны өдөр Баянхонгор аймгийн ОНХСанд 30 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн. Үлдэгдлийг 2024 оны 1-р улиралд багтаан шилжүүлнэ.	80%
15	3.1.15	Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг гадна бусад зах зээлээс авахгүй байх,	Уурхайн хүнсний хэрэглээний бүх материалыг орон нутгаас худалдан авдаг. 2023 онд Бөмбөгөр сумын 2-р багийн иргэдээс нийт 12 сая 845 мянган төгрөгийн мах, сүү, цагаан идээ худалдан авсан. Гурил будаа, төмс, хүнсний ногоо, бусад материалыг сум, аймгаас худалдаж авдаг бөгөөд 2023 онд Баянхонгор болон Бөмбөгөр сумдын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 276 сая 746 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсаргав.	100%
16	3.1.16	Бүх төрлийн татвар шимтгэлүүдийг орон нутгийн төсөвт төлдөг байх	2023 оны эхний хагасын газрын төлбөрт 20,697,456 одоогоор тушаасан. Сүүлийн хагасын ногдуулалт гараагүй байна.	100%
17	3.1.17	Ус ашигласны төлбөрийг тоолуураар хуулийн хугацаанд нь төлнө. Хэрвээ усны тоолуур суурилуулаагүй бол Эрх бүхий байгууллагаас баталсан дүгнэлтийг үндэслэн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай ноогдуулалтын гэрээ хийж, төлбөрийг орон нутагт тушаана. Ус ашигласны төлбөрийг дүгнэлтээр төлөх тохиолдолд 50-иас доошгүй хувийг ажил эхлэхэд Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна;	2023 оны усны төлбөрийг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанаас ногдуулны дагуу нийт 33,773,996 төгрөгийг татварын ерөнхий газарт тушаасан.	100%
18	3.1.18	Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх;	Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулан, усны барилга байгууламжийн зургийг мэргэжлийн байгууллагаар боловсруулсан.	100%

19	3.1.19	Техник хяналтын зардал болох 1,000,000 /нэг сая/ төгрөгийг Баянхонгор аймгийн төрийн сангийн "БХ-техник хяналтын зардал-100030051370" тоот дансанд гэрээ байгуулсны дараа байршуулна;	Техник хяналтын зардал болох 1,000,000 төгрөгийг байршуулсан.	100%
Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь			95... хувь	

ХЯНАСАН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА:

Д.МӨНХСАЙХАН

ДҮГНЭСЭН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ХИШИГБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
"АЙ ЭН ДИ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:

Д.СОДБИЛЭГ

